



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 4/308

Мандалговь

Г Газар ашиглуулах тухай 7

Монгол Улсын Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.8 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7дах, 27 дугаар зүйлийн 27.1.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Баянжаргалан сумын ИТХТэргүүлэгчдийн 2018 оны 02 дүгээр сарын 01-ны өдрийн 1/1 дугаар албан тоот, аймгийн Засаг даргын 2010 оны 454 дүгээр захирамжийн дагуу Баянжаргалан сумын нутаг дэвсгэр "Хөөт" нэртэй газарт ашигт малтмалын МУ-007944 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 1.107 42 20.54, 45 41 51.61 2. 107 41 31.54, 45 41 51.61 3. 107 41 31.54, 45 42 8.61 4. 107 42 20.54, 45 42 8.61 солбицол бүхий 55,66 /га/ газрыг уул уурхайн олборлолтын зориулалтаар "Биг могоул энд энержи" ХХК-д /5369223/ гэрээний үндсэн дээр ашиглуулсугай.

Хоёр. Дээрх аж ахуйн нэгжтэй газар ашиглах гэрээ байгуулах, газраа зориулалтын дагуу ашиглаж байгаа болон газрын төлбөрийн төлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/-д, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Баянжаргалан сумын Засаг дарга /Г.Туяа/-д, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Газар ашиглах гэрээ болон газар хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөг биелүүлж, газрын төлбөрөө гэрээний дагуу төлж байхыг газар ашиглагч аж ахуйн нэгжид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ

4998-60 8